



MONGOLIA  
MINISTRY OF FOREIGN AFFAIRS  
THE MINISTER

ДАНИЙН ХААНТ УЛСЫН ГАДААД ХЭРГИЙН САЙД  
ЭРХЭМСЭГ НОЁН ЛАРС ЛЁККЕ РАСМУССЕН ТАНАА

Копенхаген хот

Эрхэмсэг ноён сайд аа,

Монгол Улс, Данийн Хаант Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 55 жилийн ойг тохиолдуулан Танд халуун дотно мэндчилгээ дэвшүүлье.

Нэг зуун жилийн өмнө Данийн аялагч, судлаач Карл Кребс, Хэннинг Хаслунд-Кристенсен нар Монгол оронд ирж суурьшин аж ахуй эрхэлж, судалгаа шинжилгээний ажил хийж байсан нь манай хоёр орны харилцааны түүхэн эхлэл байжээ гэдгийг дурдахыг хүсэж байна.

Монгол-Данийн найрсаг харилцаа өнгөрсөн 55 жилийн хугацаанд соёл, боловсрол, хөдөө аж ахуй, худалдаа зэрэг салбарт хөгжиж ирснийг тэмдэглэхэд таатай байна.

Ардчилал, хүний эрх, эрх зүйт засаглал зэрэг нийтлэг үнэт зүйлст тулгуурласан манай хоёр орны харилцаа, хамтын ажиллагаа улс орон, дэлхий нийтийн тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахад чиглэсэн сэргээгдэх эрчим хүч, ногоон шилжилт, инновац, байгаль орчныг хамгаалах зэрэг олон салбарт улам бүр өргөжнө гэдэгт итгэлтэй байна.

Эрхэмсэг ноён сайд Танд гүн хүндэтгэлээ илэрхийлж, сайн сайхны ерөөл өргөө.

БАТМӨНХИЙН БАТЦЭЦЭГ

Улаанбаатар хот,  
2023 оны 8 дугаар сарын "5"-ны өдөр